



Г ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ж.ХАТАНБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.13 № 02/111-ЧАГ/ТАГ/2013/02-ГА

**Гэрээний хэрэгжилтийг  
хангуулах тухай**

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санүүжүүлсэн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар тус яам 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс хавсралтад дурьдсан 36 төсөл, арга хэмжээний 13,816.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу, 30.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй зөрчил, дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.15, 5.3, 5.5-д заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Дээр дурьдсан хэрэгжээгүй буюу дутуу хэрэгжсэн 36 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллах

2. Албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг гарган 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Хатанбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Дамдиндорж нарт хариуцуулан албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлага бичсэн:

АУДИТОР



Б.САРУУЛ

070350

Эрүүл мэндийн салбарын 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын дутуу буюу хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн арга хэмжээ дүнгээр (сая төгрөг)	Хэрэгжээгүй арга хэмжээ /тоогоор/	Дутуу хэрэгжсэн арга хэмжээ /тоогоор/	Тайлбар
1	Ахмадын сувиллын барилгын засвар, Сэлэнгэ	Ахмед Интернэшл Моторс" ХХК	24.8		1	Гэрээгээр 2012.11.21-нд ашиглалтанд өгөх ёстой боловч ашиглалтанд өгөөгүй гүйцэтгэгчийн буруу
2	БОЭТ-ийн гадна цэвэр бохир, дулааны шугамын засвар, Өмнөговь	Даянбайгаль ХХК	30.0	1		Эхлэх хугацаа оройтож, хүйтний улирал эхэлсэн тул ажил хийгдээгүй. 2013 оны 4-р сард эхэлнэ.
3	Эрүүл мэндийн төвийн халаалтын тогоо шинэчлэх, Ховд, Алтай	Хаш өргөө ХХК, Хос арыс ХХК	8.0		1	Алтай сум халаалтаа дуусгасан, Ховд сум материалаа татсан ажил нь ондоо багтаагүй
4	Баян-Өлгий, 20 ортой эмнэлэг	Агайын ХХК	353.4		1	Капитрон банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
5	Эрдэнэбулган сумын эмнэлгийн их засвар, Хөвсгөл	Агар-Эрдэнэс трейд ХХК	21.7		1	Технологийн зогсолт хийлгэсэн.Парапетний өрлөг хийхэд хүйтэрч орчны температур -5 хэмээс илүү гарч хүйтэрсэн тул ажлыг зогсоосон.
6	ЭМДТ, Сүхбаатар, Баруун-Урт	Аглут ХХК	0.8		1	ХХБ-ны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
7	ЭМДТ-ийн БУА, Орхон, Баян-Өндөр	Агни трейд ХХК	74.0		1	Хас банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
8	БОЭТ-ийн өргөтгөл, Өвөрхангай	Аж констракшн ХХК	263.7		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
9	ГССҮТ-ийн урсгал засвар	Антек ХХК	19.1		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
10	Геронтологийн төв, 60 ортой, Улаанбаатар	Арвис интернэйшнл ХХК	1,198.8		1	Ажлын гүйцэтгэл 47 хувьтай. Гадна инженерийн сүлжээний техникийн нөхцлийг шийдвэрлүүлэх шаардлагатай. Нэмэлт төсөв хэрэгтэй.
11	Баянтал сумын 10 ортой эмнэлгийн барилга, Говьсүмбэр	БҮҮХ ХХК	139.2		1	Эхэлж татсан материал стандартын шаардлага хангаагүйгээс дахиж материал татсанаас хугацаа алдсан гэрээ сунгагдсан ажил дуусаагүй үргэлжлэн хийгдэнэ
12	Эмнэлгийн барилга, Дундговь, Дэлгэрхангай	Бэржин Уньт ХХК	48.0		1	Ажлын гүйцэтгэл 20 хувьтай. Суурийн ажил хийгдээд хүйтэрсэн тул ажил зогссон
13	Эрүүл мэндийн төвийн барилга, 100 ортой, Улаанбаатар, Баянгол	Гангар инвест ХХК	1,340.1		1	Ажлын гүйцэтгэл 60 хувьтай, гүйцэтгэл дутуу
14	10 ортой эмнэлэг, Говь-Алтай, Цээл	Гуулин тал ХХК	34.8		1	Голомт банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
15	Даланзадгад сумын 50 ортой төрөх эмнэлгийн барилга, Өмнөговь	Жи Жи Ай ХХК	363.5		1	2012 онд хийгдэх зарим ажил хийгдээгүй.
16	50 ортой эмнэлгийн БУА, Булган	Идэр чандмань ХХК	300.2		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
17	Эмнэлгийн амбулаторийн барилга, Булган, Хутаг-Өндөр	Интеко Инженеринг ХХК	86.2		1	Ажлын гүйцэтгэл 20 хувьтай. Гүйцэтгэл дутуу
18	50 ортой төрөх эмнэлэг, Говь-Алтай, Есөнбулаг	Лайт капитал хаус ХХК	249.6		1	Голомт банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
19	Яаралтай тусламжийн төвийн парк шинэчлэлт, 30 автомашин, УБ	Монгол хьондэй автомотив ХХК	791.0		1	Ажлын гүйцэтгэл дутуу
20	50 ортой төрөх эмнэлэг, Дорноговь, Сайншанд	Монинжбар ХХК	295.0		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
21	10 ортой эмнэлэг, Дундговь, Дэлгэрцогт	Мөнхийн үргэлжлэл ХХК	26.2		1	Голомт банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн. Гэрээний хугацааг 2013.08.30 хүртэл сунгасан.

22	Эрүүл мэндийг дэмжих төв, Архангай	Нарантээл ХХК	56.2		1	Ажлын гүйцэтгэл 10 хувьтай. Гүйцэтгэл дутуу
23	Сүмбэр сумын 10 ортой төрөх эмнэлгийн барилга, Говьсүмбэр	Нэмүт контракшин ХХК	247.2		1	4 удаа гэрээ сунгаж, алданги тооцсон техникийн комисс ажилласан боловч улсын комисс хүлээж аваагүй, 2012 оны санхүүжилт оройтож ирсэн
24	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн өргөтгөлийн зураг төсөв, Орхон	Очиртааб ХХК	17.4		1	Гэрээ сунгагдаагүй, ажлын гүйцэтгэл дутуу
25	Хүн эмнэлгийн их засвар, Хэнтий, Жаргалтхаан	Очманлай ХХК	41.0		1	Цонхны чанар муу, халаалтын шугамаас ус гоождог, халаалтын төгсгөл муу. Хэрэглэгч сэтгэл хангалуун бус байна.
26	Төрөх эмнэлэг, 50 ортой, Завхан, Улиастай	РСТ ХХК	557.7		1	Ажлын гүйцэтгэл 50 хувьтай. Дулааны гадна трасс дээр барилга баригдсанаас зураг төслийн дагуу баригдах боломжгүй, нэмэлт төсөв шаардлагатай.
27	БОЭТөвийн зураг төсөв, Орхон	Санни сервис ХХК	45.0		1	Зураг төсвийг улсын экспертизээр оруулах ажил дуусаагүй шалтгаанаар өнөөг хүртэл хүлээлгэж өгөөгүй байна.
28	10 ортой эмнэлэг БУА, Хэнтий, Мөрөн	Суварга эв ХХК	79.8		1	Хас банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
29	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл, Улаанбаатар, Баянзүрх	Суурь ХХК	796.4		1	Ажлын гүйцэтгэл 50 хувьтай, гүйцэтгэл дутуу
30	20 ортой эмнэлэг, Сүхбаатар, Онгон	Тулга контракшн ХХК	43.1		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
31	Нэгдсэн эмнэлгийн засвар, Булган	Түмэн Засал ХХК	35.0		1	Ажлын гүйцэтгэл дутуу
32	10 ортой эмнэлэг, Говь-Алтай, Дэлгэр	Ус Алтай ХХК	263.8		1	Хаан банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
33	ЭМДТ-ийн БУА, Говь-Алтай	Хүчит чулуут ХХК	30.1		1	Голомт банкны баталгааг үндэслэн урьдчилж санхүүжүүлсэн.
34	Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн барилга, Улаанбаатар, Баянзүрх	Шинэ барилга ХХК	280.4		1	Гэрээт хугацааны ажлын гүйцэтгэл дутуу. Цэвэр усны эх үүсвэрийн худгийн хүчин чадал хүрэлцэхгүй.
35	Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, 20 ор, Дорнод, Хэрлэн	Эйч Жи Эй ХХК	19.1		1	Гэрээ сунгагдаагүй, ажлын гүйцэтгэл дутуу
36	Халдвартын эмнэлэг, 20 ор, Сэлэнгэ, Сүхбаатар	Эл Си Би ХХК	32.5		1	Гэрээ сунгагдаагүй, ажлын гүйцэтгэл дутуу. Халаалтын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
37	Төрөх эмнэлэг, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Нийслэл өргөө ХХК, Пума контракшн ХХК	5,633.2		1	Барилгын талбайд цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлээгүй хугацаа алдсан, барилгын суурь үерт автагдсан зэргээс гүйцэтгэл хугацаандаа хийгдээгүй. БУА-ын гүйцэтгэл 60.0 хувьтай атал 95.0 хувийн санхүүжилт авсан. БЗА-наас хийсэн барилгын материалын үнийн зөрүүд 7 550.4 сая төгрөг шаардлагатай тооцоолол нь үндэслэл муутай байна.
<b>Нийт дүн</b>			<b>13,846.0</b>		<b>1</b>	<b>36</b>